



НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2020.09.29

Шалгуур үзүүлэлт

1.1.Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, үндэсний болон дэд хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлж, шалгуур үзүүлэлтийг хангасан байх

1.4.Хүн амын дунд зонхилон тохиолдох өвчин эмгэгийн эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх, тандалт судалгаа хийж, үр дүнг тооцсон байх

- Төлөвлөгөөтэй, төлөвлөгөөнд явцын үнэлгээ хийдэг байх
- Мэргэжил арга зүйн зөвлөгөө авч хамтран ажилласан ажилласан бүртгэлийг хөтлөх, баримтжуулах
- Шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтэд үнэлгээ өгч ажиллах
- Тандалт судалгаатай ажиллах, судалгааны талаарх мэдээлэл, тоон үзүүлэлтэд үнэлгээ, дүгнэлт өгөх, авсан арга хэмжээний үр дүнг тооцдог байх

Шалгуур үзүүлэлт

1.5.Хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулдаг байх

1.7.Халдварт өвчний урьдчилан сэргийлэлт, тандалт судалгаа хийдэг байх

- Зонхилон тохиолдох ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх МСС-г тогтмолжуулах, гарын авлага, санамжийг нэмэгдүүлэх
- Халдварт өвчинд өртөх эрсдэлт бүлгийн судалгааг гаргаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах
- Халдварт өвчний тохиолдол буурсан байх
- Голомтод авсан арга хэмжээг бүртгэн баримтжуулах
- Тандалт судалгаа хийсэн байх
- Сүрьеэ, БЗДХ-ын урьдчилан сэргийлэлт, оношилгоо, эмчилгээнд иргэдийг хамруулж, үр дүнг тооцон ажиллах

Шалгуур үзүүлэлт

2.1.Хүн амын бүртгэл, мэдээллийг шинэчлэн хөтөлж, баяжилт хийдэг байх

2.2.Иргэний эрүүл мэндийн бүлэг, өрхийн эрүүл мэндийн эрсдэлийн бүлэгт үнэлгээ, дүгнэлт хийж, хяналт тогтоох, цаашид авах арга хэмжээг төлөвлөдөг байх

- Харьяаллын хүн амын бүртгэл судалгааг жил бүр шинэчилсэн байх
- Иргэний эрүүл мэндийн бүлэг, өрхийн эрүүл мэндийн эрсдэлийн бүлэгт үнэлгээг бодитой хийх, маягтыг бүрэн хөтлөх
- Авах арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтэд үнэлгээ, дүгнэлт өгч ажиллах

Шалгуур үзүүлэлт

2.3.Өөрийн харъяаллын хүн амын өвчлөлийн байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээг тодорхойлдог байх

2.4.Иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх халдварт өвчний хүчин зүйлийн тандалтыг хийдэг байх

- Судалгаа, тайлантай байх
- Авсан арга хэмжээний үр дүнг тооцох
- Халдварт өвчний хүчин ийг илрүүлэх тандалт судалгаа хийсэн, үр дүнг тооцсон байх
- Халдварт өвчин буурсан үзүүлэлттэй байх

Шалгуур үзүүлэлт

3.1. Дархлаажуулалт хийх нөхцөл, шаардлагыг хангасан байх

3.2. Хамарвал зохих хүүхдийг товлот дархлаажуулалтанд бүрэн хамруулсан байх

- ЭМ-ийн сайдын 2019 оны А/537 дугаар тушаалын арвангуравдугаар хавсралтаар баталсан “Тарилгын аюулгүй байдлын заавар”-ыг хэрэгжүүлэн ажиллах, түүнд тавих хяналтыг тогтмолжуулах
- Гар угаах, халдваргүйжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн, байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг, агааржуулалт нь MNS 6392:2013 “Эрүүл мэндийн байгууллагад мөрдөх орчны стандартын шаардлага”-ыг хангасан байна.
- Вакцин хадгалах хөргөгч термометр, тог баригчтай байна.
- Товлолын болон нөхөн дархлаажуулалтад хамруулсан бүртгэл, судалгаатай байх
- Дархлаажуулалтын үзүүлэлтийг хот, дүүрэг, улсын дундажтай харьцуусан байх



Шалгуур үзүүлэлт

4.5.Сургууль, цэцэрлэгийн эмч нарыг мэргэжил арга зүйгээр хангаж, хүүхдийн өсөлт, хөгжлийг үнэлэх, биеийн индексийг тодорхойлох болон амны хөндий гүйлсэн булчирхай, харааны эмгэгийг ирүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулдаг байх

- Сургууль, цэцэрлэгийн эмч нарыг мэргэжил арга зүйгээр хангаж, хамтран ажилласан, баримтжуулсан байх
- Хүүхдийн өсөлт, хөгжлийг үнэлэх, биеийн индексийг тодорхойлж, дүгнэлт өгөх, үнэлгээний мөрөөр тусламж үйлчилгээ үзүүлж, үр дүнг тооцох
- Хүүхдийн харааны эмгэг болон амны хөндий ГБ-н эмгэгийг ирүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгийг мэргэжлийн эмч нартай хамтран зохион байгуулах, эрүүлжүүлэх, үр дүнг тооцсон байх
- Урьдчилан сэргийлэх үзлэгийн мэдээ, тайланг нэгтгэх, дүгнэсэн байх

Шалгуур үзүүлэлт

5.3. Үйлчлүүлэгч эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл авах нөхцөлөөр хангасан байх

6.1. Урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж, эмчлэн эрүүлжүүлж, хянадаг байх

- Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн зөвлөгөө авах нөхцөлийг бүрдүүлэх
- Зөвлөгөө, мэдээлэл өгөх техник хэрэгсэл, гарын авлага, үзүүлэн материал бусад шаардлагатай хэрэгслээр хангагдсан байх
- Эрүүл мэндийн ажилтнуудыг зөвлөгөө өгөх чадварт сургах
- Тухайн жилд шинээр хийсэн МСС-ны материалын төрөл, тоог нэмэгдүүлсэн байх
- Бүртгэл, тайлан гаргасан байх



Шалгуур үзүүлэлт

6.7.Эрт илрүүлэг үзлэгийн хувь, үзүүлэлт өмнөх жилээс нэмэгдсэн байх

7.1.Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бүртгэлтэй, жил бүр баяжилт хийж, урьдчилсан сэргийлэх үзлэгт хамруулсан байх

- Умайн хүзүү, хөх, элэгний хорт хавдрын, артерийн даралт ихсэлт, чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих иргэдийг бүрэн хамруулсан тоог нэмэгдүүлсэн байх
- Хорт хавдрыг эрт үед оношилсон хувь нэмэгдсэн байх
- Илрүүлэг үзлэг тус бүрийн хувь аймаг, нийслэл, дүүргийн дундаж үзүүлэлтээс өндөр байх
- НҮНЭ-ийн бүртгэлтэй, жил бүр баяжилт хийсэн байх
- Эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан бүртгэл, судалгаатай, үнэлгээ, дүгнэлт өгсөн, шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлсэн, хяналтад авсан бүртгэлтэй байх



Анхаарал тавьсанд баярлалаа.